



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/508

Улаанбаатар хот

“Баянзүрх дүүргийн 310 дугаар цэцэрлэгийн”
эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 2,700,000.00 (хоёр сая долоон зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн ерөнхий боловсролын 164 дүгээр сургууль, Баянзүрх дүүргийн 319 дүгээр цэцэрлэгийн балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Баянзүрх дүүргийн 310 дугаар цэцэрлэг (Б.Эрдэнэцэцэг)-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг нийслэлийн ерөнхий боловсролын 164 дүгээр сургууль (Л.Даваамаа), Баянзүрх дүүргийн 319 дүгээр цэцэрлэг (Н.Энхчимэг)-т тус тус даалгасугай

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150511082



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2024 оны 164 дугаар сарын 16-ны
өдрийн 164 дугаар тусгаар хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр Баянзүрх дүүргийн 310 дугаар цэцэрлэгээс Баянзүрх дүүргийн 164 дүгээр сургуульд

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ /2024.08.31/	Хуримтлагдсан элэгдэл /2024.08.31/	Үлдэгдэл өртөг /2024.08.31/	Шилжүүлэн авах байгууллага
1	Хөлдөөгч /2 хаалгатай/	zhongguo haolenggui	2023.09.01	ш	1	2,200,000.00	2,200,000.00	549,999.96	1,650,000.04	Нийслэлийн ерөнхий боловсролын 164 дүгээр сургууль
2	Аяга таваг угаагч	монгол	2023.09.01	ш	1	500,000.00	500,000.00	99,999.96	400,000.04	Баянзүрх дүүргийн 319 дүгээр цэцэрлэг
Шилжүүлэх тоног төхөөрөмжийн нийт дүн									2,050,000.08	